



**ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
XV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 04

Зуунмод

Г Иргэнд 2020 онд газар өмчлүүлэх
ажлыг зохион байгуулах тухай Г

Иргэдэд 2020 онд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах тухай аймгийн Засаг дарга Ж.Батжаргалын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, уг асуудалд Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрмийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “з”, 19 дүгээр зүйлийн 19.1, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн иргэдэд 2020 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил тогтоолгох санал уламжлах тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 15 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолын дагуу иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Аймгийн иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулж, дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж.Батжаргал/-д даалгасугай.

2.1. Тухайн сумын иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зураглалыг сумдын 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллах.

2.2. Монгол улсын иргэнд газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлэх талаар өмнөх онуудад хийсэн ажлын эрчийг сааруулалгүй үргэлжлүүлж газар үнэгүй өмчилж авахын ач холбогдол, газрын үнэ цэнийн болон хуульд заасан хэмжээний газраа өмчилж авах талаарх сургалт сурталчилгааг оновчтойгоор зохион байгуулж, сумдад ажиллах графикчилсан төлөвлөгөөг гарган мөрдөж ажиллах, энэ ажлын талаар сум, багийн Засаг дарга, газрын даамал зэрэг холбогдох хүмүүсийн ажлын хариуцлага, сахилгыг өндөржүүлж ажиллах.

2.3. Аймгийн Засаг даргаас Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдын Засаг дарга нартай байгуулах бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд газар өмчлөлийн ажлыг тодорхой тусган дүгнэж байх.

2.4. Сумын харьяат газар өмчилж авах иргэдийн тооноос тухайн сумын нутаг дэвсгэрт газар өмчилж авсан иргэдийн тоо олон байгаа Алтанбулаг, Аргалант, Баянцогт, Сэргэлэн, Эрдэнэ, Баянчандмань сумд иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулахдаа өөрийн сумын газар өмчилж аваагүй иргэдийн болон цаашид иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлын судалгааг нарийвчлан гаргаж дүгнэлт хийж, шаардлагатай арга хэмжээ авах

0100004

2.5.Аймгийн нутаг дэвсгэрт газар өмчилсөн бусад аймаг, хотын иргэдийн харьяалал, тооны талаар нарийвчилсан судалгаа хийж, хуульд заасан өмчлүүлж болох газрын хэмжээ, байршлыг тодотгон, цаашид гадны харьяалалтай олон иргэд газар өмчилсөн нөхцөлд тэдэнд төрийн үйлчилгээг хүргэх, шаардлагатай дэд бүтцийг бий болгох зэрэг дагалдаж гарах асуудлуудыг хэрхэн шийдвэрлэхийг холбогдох газруудтай хамтран хэлэлцэж, аймгийн газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөө, тухайн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдтэй нягт уялдулан төлөвлөж байх

2.6.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6, 7 дугаар зүйлийн 7.2 болон бусад холбогдох заалтын дагуу аж ахуйн зориулалтаар аймаг, сумын төв, суурин газарт эзэмшиж байсан газраа давуу эрхээр үнээр нь өмчлөх саналыг хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Засгийн газрын тогтоолын дагуу үнийг тогтоон өмчлүүлэх.

3.Сумынхаа иргэдэд газар өмчлүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтийн явцад хяналт тавьж, энэ ажлын талаар холбогдох хүмүүсийн мэдээллийг сонсож, зохих үүрэг даалгавар өгч, шаардлагатай арга хэмжээ авч, үр дүнд хүргэж ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭНХБАТ